



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ,
СУДАЛГААНЫ ИНСТИТУТИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/301/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Н.Нямсүрэн
Утас: 261628 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Энич аудит ХХК-ийн
захирал Г.Чинтуяа
Утас: 70002115 Цахим хаяг: enichaudit@gmail.com

Улаанбаатар хот
2023 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал.....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. Аудитын илрүүлэлт.....	14
5.1 Албан шаардлага.....	15
5.2 Зөвлөмж.....	15
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СНАГ	Санхүү-нийцлийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ТАСАР

15100 Урсгалын, үнэлгээ, судалгааны
Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн
Утас 26-41-37, Утас 26-41-42
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
СУРГАЛТ, ҮНЭЛГЭЭ СУДАЛГААНЫ
ИНСТИТУТИЙНЗАХИРАЛ Б.БАТЦЭЦЭГ
ТАНАА

2023.02.17 № 07/303

танил

танил №

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2022 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 251 дүгээр тогтоолыг үндэслэн Хөдөлмөр нийгмийн хамгааллын судалгааны институт болон Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийг нэгтгэж, 2022 оны 8 дугаар сарын 4-ний өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийг шинээр байгуулсан байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/270 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Хууль ёсоор 2023.02.17 09:00:00

0001050443

Бусад асуудлын хэсэг

Тайланг онд 1 удирдах, 71 гүйцэтгэх, 3 үйлчилгээний ажилтан, нийт 75 орон тоо батлагдсанаас гүйцэтгэх албан тушаалд 68 ажилтан ажиллаж, батлагдсан бүтэц орон тооноос нийт 3 ажилтан дутуу ажилласан байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *В. М. ЦНАРАНЧИМЭГ*



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)		108,333,638.43
33	АВЛАГА		1,766,881.71
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1,766,881.71
33102	НДШ-ийн авлага		1,766,881.71
35	БАРАА МАТЕРИАЛ		106,566,756.72
35400	Хангамжийн материал		106,566,756.72
35410	Бичиг хэргийн материал		10,145,570.00
35420	Аж ахуйн материал		16,000.00
35470	Бусад хангамжийн материал		96,405,186.72
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)		1,618,138,151.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ		1,618,138,151.67
39200	Биет хөрөнгө		1,613,225,964.72
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,413,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга		(239,775,035.02)
39203	Авто-тээврийн хэрэгсэл		218,077,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл		(218,077,700.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)		678,494,764.93
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж		(401,472,625.34)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		359,906,290.57
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга		(202,576,505.63)
39217	Номын фонд		5,551,000.00
39300	Биет бус хөрөнгө		4,912,186.95
39301	Программ хангамж		95,908,611.79
39302	Хуримтлагдсан элэгдэл - Программ хангамж		(90,996,424.84)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)		1,726,471,790.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)		2,834,679.25
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		2,834,679.25
41300	Өглөг		2,834,679.25
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,834,679.25
41311	Цалингийн өглөг		1,312,423.93
41313	ХАОАТ-ын өглөг		1,522,255.32
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)		1,723,637,110.85
51	Засгийн газрын хувь оролцоо		1,723,637,110.85
512	Хуримтлагдсан үр дүн		1,723,637,110.85
51220	Тайлант үеийн үр дүн		1,723,637,110.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)		1,726,471,790.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,793,810,346.02
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,971,820,753.09
120	Нийтлэг татварын бус орлого		1,971,820,753.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		170,632,012.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		170,632,012.14

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,697,624,877.23
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - материал	103,563,863.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	821,989,592.93
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	657,624,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	657,624,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	164,364,792.93
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд нэмэлт орлого	164,364,792.93
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,105,966,608.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,105,966,608.17
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,401,302.53
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	481,627,969.60
210101	Үндсэн цалин	306,570,446.94
210102	Нэмэгдэл	66,859,242.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	57,006,230.52
210104	Урамшуулал	28,395,195.00
210105	Гэрээт ажлын цалин	22,796,854.54
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,832,479.01
210201	Тэтгэврийн даатгал	40,541,597.30
210202	Тэтгэмжийн даатгал	4,769,599.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,674,559.58
210204	Ажилгүйдлийн даатгал	892,890.69
210205	Эрүүл мэндийн даатгал	8,953,832.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,264,100.38
210301	Гэрэл, цахилгаан	1,733,911.57
210302	Түлш, халаалт	3,050,678.10
210303	Цэвэр, бохир ус	2,479,510.71
2104	Хангамж, бараа материалын зардал	28,276,651.10
210401	Бичиг хэрэг	15,917,880.00
210402	Тээвэр, шатахуун	1,535,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,781,958.10
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,041,813.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00
2107	Томилолт, зочны зардал	381,200.00
210702	Дотоод албан томилолт	381,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,945,580.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	594,220.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,351,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	120,873,322.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,889,861.88
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	32,367,135.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	85,616,325.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,565,305.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,438,036.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,180,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,257,436.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	340,127,269.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	340,127,269.64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,687,843,737.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	35,793,373.00
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	35,793,373.00

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

140	Төсөвт байгууллагын орлого		35,793,373.00
140020	Дансны орлого		35,793,373.00
5	НИЙТ ҮР ДҮН (V=III+IV)		1,723,637,110.85

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		1,028,414,978.07
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		170,632,012.14
120	Нийтлэг татварын бус орлого	-	170,632,012.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	170,632,012.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		170,632,012.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		857,782,965.93
1310	Улсын төсвөөс		657,624,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		657,624,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		200,158,165.93
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		200,158,165.93
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)		1,028,414,978.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,028,414,978.07
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		629,849,672.43
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		481,537,505.06
210101	Үндсэн цалин		306,570,446.94
210102	Нэмэгдэл		66,859,242.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт		57,006,230.52
210104	Урамшуулал		28,395,195.00
210105	Гэрээт ажлын цалин		22,706,390.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		58,832,479.01
210201	Тэтгэврийн даатгал		40,541,597.30
210202	Тэтгэмжийн даатгал		4,769,599.43
210203	ҮОМШӨ-ний даатгал		3,674,559.58
210204	Ажилгүйдлийн даатгал		892,890.69
210205	Эрүүл мэндийн даатгал		8,953,832.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		7,264,100.38
210301	Гэрэл, цахилгаан		1,733,911.57
210302	Түлш, халаалт		3,050,678.10
210303	Цэвэр, бохир ус		2,479,510.71
2104	Хангамж, бараа материалын зардал		27,776,299.10
210401	Бичиг хэрэг		10,920,316.00
210402	Тээвэр, шатахуун		389,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		8,781,958.10
210404	Ном, хэвлэл		3,948,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,737,025.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		5,233,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		5,233,600.00
2107	Томилолт, зочны зардал		381,200.00
210702	Дотоод албан томилолт		381,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,259,752.00

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,408,392.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,851,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,564,736.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,621,936.88
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	32,942,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,565,305.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	58,438,036.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,180,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,257,436.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	340,127,269.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	340,127,269.64
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Тайлант үеийн үр дүн			
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			
Тайлант үеийн үр дүн		1,723,637,110.85	1,723,637,110.85
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		1,723,637,110.85	1,723,637,110.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	788,333,900.00	636,702,619.45	151,631,280.55	80.8
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	722,189,400.00	578,264,583.45	143,924,816.55	80.1
УРСГАЛ ЗАРДАЛ	722,189,400.00	578,264,583.45	143,924,816.55	80.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,189,400.00	578,264,583.45	143,924,816.55	80.1

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	581,338,200.00	458,831,115.06	122,507,084.94	78.9
Үндсэн цалин	319,667,300.00	306,570,446.94	13,096,853.06	95.9
Нэмэгдэл	184,608,100.00	66,859,242.60	117,748,857.40	36.2
Унаа хоолны хөнгөлөлт	71,219,400.00	57,006,230.52	14,213,169.48	80.0
Урамшуулал	5,843,400.00	28,395,195.00	(22,551,795.00)	485.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,502,100.00	58,832,479.01	19,669,620.99	74.9
Тэтгэврийн даатгал	54,966,400.00	40,541,597.30	14,424,802.70	73.8
Тэтгэмжийн даатгал	5,789,500.00	4,769,599.43	1,019,900.57	82.4
ҮОМШӨ-ний даатгал	4,702,200.00	3,674,559.58	1,027,640.42	78.1
Ажилгүйдлийн даатгал	1,180,800.00	892,890.69	287,909.31	75.6
Эрүүл мэндийн даатгал	11,863,200.00	8,953,832.01	2,909,367.99	75.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,914,300.00	7,264,100.38	650,199.62	91.8
Гэрэл, цахилгаан	1,424,700.00	1,733,911.57	(309,211.57)	121.7
Түлш, халаалт	3,572,200.00	3,050,678.10	521,521.90	85.4
Цэвэр, бохир ус	2,917,400.00	2,479,510.71	437,889.29	85.0
Хангамж, бараа материалын зардал	19,647,600.00	19,625,097.00	22,503.00	99.9
Бичиг хэрэг	8,103,600.00	8,103,702.00	(102.00)	100.0
Тээвэр, шатахуун	329,000.00	329,000.00		100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,416,900.00	7,455,370.00	961,530.00	88.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,798,100.00	3,737,025.00	(938,925.00)	133.6
Эд хогшил, урсгал засварын зардал	5,242,500.00	5,233,600.00	8,900.00	99.8
Багаж, техник хэрэгсэл	5,242,500.00	5,233,600.00	8,900.00	99.8
Томилолт, зочны зардал	381,200.00	381,200.00		100.0
Дотоод албан томилолт	381,200.00	381,200.00		100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	12,147,000.00	11,128,392.00	1,018,608.00	91.6
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,429,800.00	2,408,392.00	21,408.00	99.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	6,011,500.00	6,000,000.00	11,500.00	99.8
Даатгалын үйлчилгээ	220,600.00		220,600.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	76,800.00		76,800.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,369,400.00	2,720,000.00	649,400.00	80.7
Газрын төлбөр	38,900.00		38,900.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	17,016,500.00	16,968,600.00	47,900.00	99.7
Бараа үйлчилгээний бусад зардал	974,900.00	927,000.00	47,900.00	95.1
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,041,600.00	16,041,600.00		100.0
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	66,144,500.00	58,438,036.00	7,706,464.00	88.3
УРСГАЛ ЗАРДАЛ	66,144,500.00	58,438,036.00	7,706,464.00	88.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,144,500.00	58,438,036.00	7,706,464.00	88.3
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,180,600.00	25,180,600.00		100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,963,900.00	33,257,436.00	7,706,464.00	81.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	788,333,900.00	636,702,619.45	151,631,280.55	80.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	591,659,400.00	399,926,107.31	191,733,292.69	67.6
Улсын төсвөөс санхүүжих	591,659,400.00	399,926,107.31	191,733,292.69	67.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	130,530,000.00	170,632,012.14	(40,102,012.14)	130.7

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,530,000.00	170,632,012.14	(40,102,012.14)	130.7
Татварын бус орлого	66,144,500.00	66,144,500.00		100.0
Тусламжийн орлого	66,144,500.00	66,144,500.00		100.0
Төсвөөс санхүүжих	66,144,500.00	66,144,500.00		100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
АЖИЛЛАГСДЫН ТОО	75	72	3	96.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	71	68	3	95.8
Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)		200,158,165.93
УРСГАЛ ЗАРДАЛ		200,158,165.93
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		51,585,088.98
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил		22,706,390.00
Гэрээт ажлын цалин		22,706,390.00
Хангамж, бараа материалын зардал		8,151,202.10
Бичиг хэрэг		2,816,614.00
Тээвэр, шатахуун		60,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		1,326,588.10
Ном, хэвлэл		3,948,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,131,360.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		2,131,360.00
Бараа үйлчилгээний бусад зардал		18,596,136.88
Бараа үйлчилгээний бусад зардал		1,694,936.88
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		16,901,200.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		148,573,076.95
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		148,573,076.95
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)		200,158,165.93
Нэмэлт санхүүжилтийн орлого		200,158,165.93
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		200,158,165.93
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *"төрөөс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, хөтөлбөрийн судалгаа, шинжилгээ хийж, бодлого боловсруулагч нарт зориулсан зөвлөмж боловсруулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг тодорхойлох"* гэж тодорхойлж, түүнд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар олгох сургалт, бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, үнэлгээ, чанарын баталгаажуулалт хийх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний хэтийн төлөвийг тодорхойлох, хөдөлмөрийн харилцааны асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, бодлогын зөвлөмж боловсруулах;
- Нийгмийн даатгал, тэтгэврийн бодлого, итгэлцүүр, сангийн удирдлага, үйлчилгээний цахимжилтийн үр нөлөөний асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, бодлогын зөвлөмж боловсруулах;
- Нийгмийн халамжийн бодлого, зорилтот бүлгийн халамжийн үйлчилгээний арга аргачлал, хүн амын хөгжлийн бодлогын асуудлаар эрдэм шинжилгээний судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн үр дүнд судалгаа, шинжилгээ хийх, дүгнэлт өгөх, бодлогын зөвлөмж боловсруулах;
- Ажил мэргэжлийн ангилал, ур чадварын хангамж, эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийж, хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар олгох сургалтын болон гадаад ажиллах хүчний хэрэгцээг тодорхойлох, төгсөгчдийн мөшгөх судалгааг тогтмол хийх, хамрах хүрээг өргөжүүлэх;
- Хөдөлмөрт бэлтгэх, ур чадвар олгох сургалтын багш нарыг чадавхжуулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, нэгдсэн арга зүйгээр хангах, мэргэшлийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт хэрэгжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай";
- Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол "Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай";
- Засгийн газрын 2022 оны 203 дугаар тогтоол "Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай";
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай";
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаал "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам";
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар".

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцаад гүйцэтгэх үе шатанд

хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А/270 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг, тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,082,355.1 мянган төгрөгөөр буюу 11.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		1,766.9	1,766.9
Бараа материал		106,566.8	106,566.8
Үндсэн хөрөнгө		1,618,138.1	1,618,138.1
Нийт хөрөнгө		1,726,471.8	1,726,471.8
Өр төлбөр		2,834.7	2,834.7
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		1,723,637.1	1,723,637.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		1,726,471.8	1,726,471.8

Авлага дансны 1,766.1 мянган төгрөгийн үлдэгдэл нь нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага байна.

Бараа материалын дансны 106,566.8 мянган төгрөгийн үлдэгдэл нь үнэ төлбөргүй хүлээн авсан 103,563.9 мянган төгрөгийн бараа материал, сүүлийн 3 сард худалдан авсан 3,002.9 мянган төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материалыг зарцуулаагүйгээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны 1,618,138.1 мянган төгрөгийн үлдэгдэл нь худалдан авсан 4,629.6 мянган төгрөгийн компьютер, принтер, 1,500.0 мянган төгрөгийн программ хангамж, 1,697,624.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөр нэмэгдэж, 85,616.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаас шалтгаалжээ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өр төлбөр дансны 2,834.7 мянган төгрөгийн үлдэгдэл нь 1,312.4 мянган төгрөгийн цалингийн өглөг, 1,522.3 мянган төгрөгийн хувь хүний орлогын татварын өглөгийн төлбөр барагдуулаагүйгээс үүсжээ.

Засгийн газрын оролцоо дансны 1,723,637.1 мянган төгрөгийн үлдэгдэл нь үйл ажиллагааны тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан 1,801,188.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал нөлөөлсөн байна.

2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,793,810.3 мянган төгрөг, урсгал зардалд 1,105,966.6 мянган төгрөг зарцуулж, 1,723,637.1 мянган төгрөгийн үр дүн гарсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 657,803.9 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 130,530.0 мянган төгрөг, нийт зарлагыг 788,333.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийг саналын дагуу нийт зарлагыг 788,333.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 591,659.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 66,144.5 мянган төгрөгийг урсгал шилжүүлэгт, 130,530.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 399,926.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал шилжүүлэгт 66,144.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 170,632.0 мянган төгрөг, нийт 636,702.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 636,702.6 мянган төгрөг буюу 80.8 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 142,173.7 мянган, байр ашиглалтын зардалд 650.2 мянган, хангамж, бараа материалын зардалд 22.5 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,018.6 мянган, бараа, үйлчилгээний бусад зардалд 47.9 мянган, эд хогшил, урсгал засварын зардалд 8.9 мянган, урсгал шилжүүлгийн зардалд 7,706.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 151,631.3 мянган төгрөгөөр, 1 хөтөлбөр 143,924.8 мянган төгрөг, 2 арга хэмжээ 7,706.5 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
				Зөрүү	Биелэлт
1	72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	788,333.9	636,702.6	151,631.3	80.8
1.1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	722,189.4	578,264.6	143,924.8	80.1
1.2	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	66,144.5	58,438.0	7,706.5	88.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 2,243.1 мянган, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 39,900.3 мянган, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжийн орлого 158,014.8 мянган төгрөгөөр, нийт 200,158.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардалд 22,706.4 мянган, хангамж, бараа материалын зардалд 8,151.2 мянган, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 2,131.4 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 18,596.1 мянган, нийт 51,585.1 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 148,573.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах, төсвийн хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Энич аудит ХХК-ийн ахлах аудитор Н.Наран, аудитор Д.Уртнасан нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Г.Чинтуяа хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 01 сарын 25-ны өдрийн 1/34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны батлагдсан төсөв, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн батлагдсан төсвийн нийт зардал 788,333.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,883.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой батлагдсан бүтэц орон тооноос нийт 3 ажилтан дутуу ажилласанаас 142,176.7 мянган төгрөгийн цалин, нийгмийн

даатгалын, 9,454.6 мянган төгрөгийн урсгал зардлын хэмнэлт гаргаж, төсөвт 191,554.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 12 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих нийт 45 мэдээллээс 42 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээлэл хугацаа хоцроосон, 5 сая төгрөгөөс дээш 31,180.6 мянган төгрөгийн 2 мэдээ оруулахаас 31,180.6 мянган төгрөгийн 2 мэдээ байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.10."Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна", гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулж байх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 95,848.4 мянган төгрөгийн 1 алдаа илрүүлснээс зөвлөмжийн дагуу алдааг залруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй дуу бичлэгийн студийн зориулалттай үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг борлуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байдалд анхаарах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,559.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлд капиталжих их засварын 105,559.3 мянган төгрөгийн зардлыг тусад нь илэрхийлснийг барилгын өртөгт залруулж бүртгэсэн.

Аудитаар нийт 7,772.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7,272.0 мянган төгрөгийн төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

1. Зардлын данстай холбоотой асуудал

Ахмадуудыг хүлээн авч бэлэг дурсгалд 500.0 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 "Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.2 Илрүүлэлт: Тайлант онд 4,249,8 мянган төгрөгөөр компьютер, принтер худалдан авч, үндсэн үйл ажиллагааны зардлаас хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.3 "Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтөнд шаардлагатай хөрөнгө, зардлыг ангилан тусгаж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх.

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Байгууллага нь Axplore 3.52, Acolous санхүүгийн програмтай ба нэмж Динамик санхүүгийн программ 1,500.0 мянган төгрөгөөр худалдан авч хэмнэж болох зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 22 дугаар зүйлийн 22.6.3 "Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх." гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөлтөнд шаардлагатай хөрөнгө зардлыг ангилан тусгаж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байх.

3. Авлага, өглөгийн данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд ХХОАТ-ын 1,522.2 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



20 дугаар зүйлийн 20.2.5. "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын төлбөр, тооцоог тухай бүр хийж, тооцоо нийлж баталгаажуулан төсвийг зохистой удирдаж ажиллах.

4.Үндсэн хөрөнгө, бараа материалын данстай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй дуу бичлэгийн студийн зориулалттай 31 ширхэг 51,508.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 339 ширхэг 51,445.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дуу бичлэгийн студийн зориулалттай үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг дээд шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Капиталжих их засварын зардлыг барилгын өртөгт тусгалгүй, үндсэн хөрөнгийн жагсаалтад тусад нь илэрхийлсэн байна.	1	105,559.3					1	105,559.3				
Дүн		105,559.3					1	105,559.3				

/Мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд компьютер, принтер худалдан авч, үндсэн үйл ажиллагааны зардлаас хөрөнгө бэлтгэсэн	1	4,249.8					1	4,249.8				
Ахмадуудыг хүлээн авч, бэлэг дурсгалын зүйлийн зардал гаргасан байна.	1	500.0			1	500.0						
Байгууллага нь Ахрлогег 3.52, Аcolous санхүүгийн програмтай ба нэмж Динамик санхүүгийн программ худалдан авч хэмнэж болох зардал гаргасан. Худалдан авсан биет бус хөрөнгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд мэдээлэл технологийн үйлчилгээ дансанд бүртгэсэн.	1	1,500.0					1	1,500.0				
2022 оны жилийн санхүүгийн тайланд ХХОАТ-ын өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	1,522.2					1	1,522.2				

Үүнээс:

/Мянган төгрөгөөр/



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй дуу бичлэгийн студийн зориулалттай 31 ширхэг 51,508.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 339 ширхэг 51,445.5 мянган төгрөгийн бараа материал бүртгэлтэй байна.	1	-					1	500.0	4	7,272.0	
Дүн	5	7,772.0					1	500.0	4	7,272.0	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансанд нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай 2 мэдэгдэл, байгууллагын батлагдсан төсвийн 1 мэдээг хугацаа хоцроож байршуулсан.	1	-			1		-
Дүн	1	-			1		-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 дугаар сарын 21 № 129/А0150458

Улаанбаатар хот

СНАГ - 2023/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд ахмадуудыг хүлээн авч 500,000.00 төгрөгийн бэлэг дурсгалын зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.5 "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж, хуулиар зөвшөөрөгдөөгүй зардал гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирал Б.Батцэцэг, ерөнхий нягтлан бодогч О.Мандухай нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.НАЦАГДОРЖ

ЭНИЧ-АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Г.ЧИНТУЯА